

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/60/НА-СТА-ТӨҮГ

Цахим
хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: Dolgorsuren.B@audit.mn
Аудитор С.Шийлэгмаа
Утас: 261628 Цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn
Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал Л.Насанбуян
Утас: 99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	13
3.6 Худалдан авах ажиллагаа	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТДЦС	Тавантолгой дулааны цахилгаан станц
ЭХЯ	Эрчим хүчний яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ТЭНГЭР ТАНАА

2026.03.16 № 06/666
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 130.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тус байгууллага нэг иргэнтэй гэрээ байгуулж, оффисын талбайн түрээс, ашиглалт үйлчилгээний төлбөрт ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1.м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг хэтрүүлэн 73.2 сая төгрөгийн илүү зардал гаргасан;
- Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн 5.5 сая төгрөгийн шатахуун олгосон;
- Анхан шатны баримт дутуу 7.6 сая төгрөгийн шатахуун, албан томилолтын мөнгийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцтэй бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын "Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 32 дугаар тогтоолын 1.2 дахь заалтаар Тавантолгой дулааны цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах болон бэлтгэл ажилд зориулан олгосон үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 2028 он хүртэл үе шаттайгаар жил бүр хуваарийн дагуу төлж барагдуулахыг Эрдэнэс Монгол ХХК болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөгжлийн банктай байгуулсан "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай" 2014 оны 3-ДЦ-Б2014-09 дугаар зээлийн гэрээний дагуу олгосон 14.8 сая ам. долларын зээл, зээлийн хүүгийн төлбөрийн эргэн төлөлт хийгдээгүйгээс тайлант онд 3,266.5 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал, 2,572.9 сая төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдлыг бүртгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,742,239,890.9	1,550,047,664.91
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	253,948,546.1	287,306,275.28
1.1.4	Бусад авлага	3,656,144.8	3,410,042.47
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,700,000,000.0	
1.1.6	Бараа материал	910,731,245.5	915,685,030.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	19,051,897.6	14,707,269.35
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	15,587,704,340.5	15,587,704,340.50
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,217,332,065.4	18,358,860,623.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	342,286,518.0	339,298,622.39
1.2.2	Биет бус хөрөнгө	5,419,068,454.5	6,310,365,872.73
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,761,354,972.5	6,649,664,495.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,978,687,037.9	25,008,525,118.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өглөг	20,642,836.5	
2.1.1.5	Зээлийн хүүгийн өглөг	13,570,769,788.8	16,697,274,331.37
2.1.1.9	Бусад богино хугацаат өр төлбөр	33,227,070.4	350,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,624,639,695.7	16,697,624,331.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	50,675,282,482.8	52,696,367,281.66
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	50,675,282,482.8	52,696,367,281.66
2.2	Өр төлбөрийн нийт дүн	64,299,922,178.5	69,393,991,613.03
2.3	Эздийн өмч	5,858,716,244.7	5,858,716,244.72
2.3.1	Өмч : а) төрийн	5,858,716,244.7	5,858,716,244.72
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		52,333,606.35
2.3.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	12,445,358,000.0	13,338,708,600.00
2.3.8	Хуримтлагдсан ашиг	(56,625,309,385.3)	(63,635,224,945.95)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(38,321,235,140.5)	(44,385,466,494.88)
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,978,687,037.9	25,008,525,118.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	Борлуулалтын орлого /цэвэр/	-	-
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
5	Хүүгийн орлого	168,720,971.1	225,783,826.00
8	Бусад орлого	9,158,605.6	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,675,559,944.2	1,398,161,199.66
11	Санхүүгийн зардал	3,125,487,634.5	3,266,495,115.22
12	Бусад зардал	54,094,327.9	23,360,215.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	(197,927,734.7)	(2,526,384,778.43)
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	(54,120,000.0)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,929,310,064.7)	(6,988,617,482.95)
19	Орлогын татварын зардал	16,566,191.6	21,298,077.75
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,945,876,256.3)	(7,009,915,560.70)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,945,876,256.3)	(7,009,915,560.70)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,858,716,244.7		12,445,358,000.0	(56,625,309,385.3)	(38,321,235,140.5)
9	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	5,858,716,244.7	-	12,445,358,000.0	(56,625,309,385.3)	(38,321,235,140.5)
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			893,350,600.0	(7,009,915,560.7)	(6,116,564,960.7)
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		52,333,606.4			52,333,606.4
18	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	5,858,716,244.7	52,333,606.4	13,338,708,600.0	(63,635,224,946.0)	(44,385,466,494.9)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	99,850,827.4	4,594,200.50
1.1.6	Бусад мөнгөн орлого	99,850,827.4	4,594,200.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,997,967,341.8	2,114,575,847.24
1.2.1	Ажиллагчдад төлсөн	714,409,340.7	672,241,415.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	191,810,254.4	172,263,914.12
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	21,173,265.0	1,373,500.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	231,629,697.8	114,743,592.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	59,358,751.0	32,420,945.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		691,830,186.91
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	86,380,328.6	95,846,064.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,619,390.0	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	684,586,314.2	333,856,228.94
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,898,116,514.4)	(2,109,981,646.74)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	152,285,206.4	225,783,826.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	152,285,206.4	225,783,826.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	152,285,206.4	225,783,826.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,864,500.0	17,980,916.82
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,864,500.0	-
2.2.5	Бусдад олгосон зээл, болон урьдчилгаа	-	17,980,916.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	145,420,706.4	207,802,909.18
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	300,000,000.0	2,070,062,241.86
3.1.2	Бусад	300,000,000.0	2,070,062,241.86
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,000,000,000.0	406,615,364.96
3.2.1	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		406,615,364.96
3.2.3	Бусад	2,000,000,000.0	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,700,000,000.0)	1,663,446,876.90
3.3.1	Валютын ханшийн зөрүү	2,931,510.4	46,539,634.67
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,449,764,297.6)	(192,192,225.99)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,192,004,188.5	1,742,239,890.90
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,742,239,890.9	1,550,047,664.91

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Нийт орлого	177,879.5	4,964,800.0	225,783.8	47,904.3	126.9	(4,739,016.2)	4.5
үйл ажиллагааны бус орлого	177,879.5	4,964,800.0	225,783.8	47,904.3	126.9	(4,739,016.2)	4.5
Нийт зардал	5,107,189.6	4,962,710.0	7,214,401.3	2,107,211.7	141.3	2,251,691.3	145.4
Үүнээс: Удирдлагын зардал	1,729,654.3	1,727,900.0	1,398,161.2	(331,493.1)	80.8	(329,738.8)	80.9
Татварын өмнөх ашиг	(4,929,310.1)	2,090.0	(6,988,617.5)	(2,059,307.4)	141.8	(6,990,707.5)	(334,383.6)
Цэвэр ашиг /алдагдал/	(4,945,876.2)	1,881.0	21,298.1	4,967,174.3	(0.4)	19,417.1	1,132.3
Төсвийн төлбөрт нийт дүн	303,029.8	303,018.7	277,465.0	(25,564.7)	91.6	(25,553.7)	91.6
а/ Орлогын татварт	16,566.2	21,998.4	21,789.4	5,223.2	131.5	(209.0)	99.1
в/ НДШ	191,810.3	191,810.3	172,813.8	(18,996.4)	90.1	(18,996.5)	90.1
г/ Хүн амын орлогын татвар	79,668.6	79,668.6	73,320.4	(6,348.3)	92.0	(6,348.2)	92.0
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар /газрын/	14,393.4	8,218.8	8,218.8	(6,174.5)	57.1	0.0	100.0
з/ Тээврийн хэрэгслийн татвар	591.3	1,322.6	1,322.6	731.3	223.7	-	100.0
Нийт ажиллагсдын тоо	18.0	16.0	12.0	(6.0)	66.7	(4.0)	75.0
Нийт цалингийн сан	842,200.0	842,200.0	778,700.1	(63,499.9)	92.5	(63,499.9)	92.5
Нэг ажиллагчийн дундаж цалин	46,788.9	52,637.5	64,891.7	18,102.8	138.7	12,254.2	123.3
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	-	-
Нийт авлага	257,604.7	104,000.0	290,716.3	33,111.6	112.9	186,716.3	279.5
Үүнээс: Найдваргүй	-	-	-	-	-	-	-
Нийт өглөг	64,299,922.2	65,382,100.0	69,393,991.6	3,909,452.0	107.9	4,011,891.6	106.1
Богино хугацаат өр төлбөр	13,624,639.6	13,522,200.0	16,697,624.3	3,072,984.7	122.6	3,175,424.3	123.5
Урт хугацаат өр төлбөр	51,859,900.0	51,859,900.0	52,696,367.3	836,467.3	101.6	836,467.3	101.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын “Тавантолгой цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 124 дүгээр тогтоолоор өмнөд бүсийн уул уурхайн болон Оюутолгой төслийн эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит Тавантолгой дулааны цахилгаан станц хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани мөн бөгөөд нийт хувьцааны 51.0 хувийг Эрчим хүчний яам, 30.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК, 19.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

Компанийн үндсэн зорилго нь Тавантолгой цахилгаан станц төслийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулснаар Өмнийн бүсийн уул уурхайн болон Оюутолгой төслийн эрчим хүчний хэрэглээг найдвартай бүрэн хангахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Санхүүжилтийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцах;
2. Барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
3. Станцын үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн, Оюутолгой болон Өмнийн говийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь үйл ажиллагаандаа дараах хуулиудыг мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус компани нь дотоод хяналтын ажилтан байхгүй, тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй байгаатай холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 970.1 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,742,239.9	1,550,047.6	(192,192.2)
Авлага	257,604.7	290,716.3	33,111.6
Бусад санхүүгийн хөрөнгө	1,700,000.0	0.0	(1,700,000.0)
Бараа материал	910,731.2	915,685.0	4,953.8
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	19,051.9	14,707.3	-4,344.6
Бусад эргэлтийн хөрөнгө	15,587,704.3	15,587,704.3	00
Үндсэн хөрөнгө	5,761,354.9	6,649,664.5	888,309.5
Нийт хөрөнгө	25,978,687.0	25,008,525.1	(970,161.9)
Өр төлбөр	64,299,922.2	69,393,991.6	5,094,069.4
Эздийн өмчийн дүн	(38,321,235.1)	(44,385,466.5)	(6,064,231.3)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	25,978,687.0	25,008,525.1	(970,161.9)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс, бусад санхүүгийн хөрөнгийн данс, үндсэн хөрөнгийн данс, Хөгжлийн банкны зээл, зээлийн хүүгийн өсөлттэй холбоотойгоор өр төлбөр, эздийн өмчийн данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,550.0 сая төгрөг байгаагаас Голомт банкны харилцах дансанд 136.2 сая төгрөг, ХААН банканд хугацаатай хадгаламжийн дансанд 1,000.0 сая төгрөг, 115.9 мянган ам.долларыг тус тус байршуулсан;
- Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө хүүгийн орлого 225.7 сая төгрөг, валютын ханшийн зөрүүгээс 46.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, хөгжлийн банкны зээлийн хүүгийн төлбөрт 691.8 сая төгрөг, тайлант хугацааны урсгал үйл ажиллагааны зардалд 1,472.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Авлага дансны үлдэгдэл 290.7 сая төгрөг байгаа нь НӨАТ-ын авлага 286.7 сая төгрөг, шатахууны картын үлдэгдэл 3.3, бусад авлага 0.7 сая төгрөг байна;

- Өмнөх жилд хадгаламжийн дансанд байсан 1,700.0 сая төгрөгийг бусад санхүүгийн хөрөнгө дансанд бүртгэсэн байсныг тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн;
- Бараа материал дансны үлдэгдэл 915.6 сая төгрөг байгаагийн 134.8 сая төгрөг нь ашиглалтад байгаа болон агуулахад байгаа хангамжийн материал, 9.2 сая төгрөгийн шатахуун, 771.6 сая төгрөг нь төслийн ажил эхлэхэд хэрэглэгдэх багаж техник, тоног төхөөрөмж, компьютер, бусад хэрэгслүүд агуулахад хадгалагдаж байна;
- Бусад эргэлтийн хөрөнгө 15,587.7 сая төгрөг нь төсөл хэрэгжүүлэх ажлын талбар дээр хийгдсэн 6 ширхэг худаг, түүнтэй холбоотой гарсан зардлыг хуримтлуулж бүртгэсэн байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 888.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд 21.3 сая төгрөгийн техник, хэрэгсэл худалдан авч 893.3 сая төгрөгийн газар эзэмших эрх нэмж бүртгэж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 145 хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж 52.3 сая төгрөгөөр өртгийг нэмж бүртгэж, 78.6 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож санхүүгийн тайланд тусгасан;
- Өр төлбөр 69,394.0 сая төгрөг болж, 5,094.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд зээлийн хүүгийн зардал 3,266.5 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний гарз 2,526.4 сая төгрөгийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд зээлийн хүүгийн төлбөрт 691.8 сая төгрөг төлсөн;
- Эздийн өмч дансны өөрчлөлт нь тайлант үеийн үр дүн, өр төлбөрийн өсөлтөөс хамааралтай байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлагдсантай уялдуулан компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Зорилтот түвшнийг батлахдаа нийт орлого буюу хөрөнгө оруулалтын санхүүжилтийн орлогыг 4,964.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 1,727.9 сая төгрөг, банкны зээлийн хүүгийн зардлыг 3,234.8 сая төгрөгөөр төлөвлөж, 2.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталсан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын санхүүжилтын орлого байхгүй, хүүгийн орлогоор 225.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 7,214.4 сая төгрөгийн зардал гарган, 6,988.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 7,214.4 сая төгрөгөөс удирдлагын зардал 1421.5 сая төгрөг, зээлийн хүүгийн зардал 3,266.5 сая төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний гарз 2,526.4 сая төгрөг байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал төлөвлөөгүй байна.

3.6 Худалдан авах ажиллагаа

Тус компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг захирлын А/01 дугаар тушаалаар баталсан. Тус төлөвлөгөөнд 262.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төрлийн бараа, ажил, үйлчилгээнээс 249.9 сая төгрөгийг тайлант онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 120.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй оффисын түрээсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тендерт шалгарсан иргэнтэй 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр сарын 10.0 сая төгрөгийн түрээсийн гэрээ байгуулсан.

Мөн тус иргэнтэй сарын 9.8 сая төгрөгийн ашиглалт, үйлчилгээний гэрээг нэмж байгуулсан бөгөөд энэ зардлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Шууд худалдан авах аргаар 25.3 сая төгрөгийн шингэрүүлсэн түлш, шатахуун, 21.3 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, 32.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэг, даатгал, ажилчдын эрүүл мэндийн үйлчилгээг худалдаж авсан байна.

Төслийн ерөнхий гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын ажлын явцаас хамаарч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ус хангамжийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажил, ус хангамжийн газрын хянан баталгаа, кадастрын зураг хийх, “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд мод тарих ажил зэрэг 67.0 сая төгрөгийн зарим төсөл, арга хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр 2026 онд шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитын үндсэн чиглэлийн дагуу хийсэн судалгааны үр дүнгийн талаар:

1. Тус компанийн 2025 оны бүтэц, орон тоог 16 хүнтэй байхаар баталснаас гүйцэтгэлээр 10 үндсэн ажилтан, 1 гэрээт ажилтан ажилласан.
2. Ажилчдад өдөрт 9.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт, 1.0 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт олгодог бөгөөд тайлант онд нийт 21.4 сая төгрөг зарцуулсан.
3. Гадаад томилолтын зардалд 13.1 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6.2 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэх захирал Г.Тэнгэр нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас өгсөн урилгын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Польш улсад айлчлах айлчлалын үеэр зохион байгуулагдах “Монгол-Чехийн бизнес форум” болон “Монгол-Польшийн бизнес форум”-д оролцсон.
4. Сургалтын зардалд Эрчим хүчний үндэсний төв дээр зохион байгуулагдсан 4 удаагийн сургалт, худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаарх 1 удаагийн сургалтад нийт 2.3 сая төгрөг зарцуулсан.
5. Тайлант хугацаанд хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаа болон төрд учруулсан хохирлыг нөхөн төлсөн зардал гараагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК -ийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, гэрээт аудитор Л.Хонгорзул нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Шийлэгмаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 5,086.9 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 50.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр горим сорил хэрэгжүүлэхэд тус хуулийн хязгаарласан заалтуудтай холбоотой дараах зөрчил илэрлээ.

Илрүүлэлт: Эрчим хүчний сайдын 2025 оны А/31 дүгээр тушаалаар нийт ажиллагсдыг 16 байхаар баталсан бөгөөд тайлант оны эцсээр 10 үндсэн ажилтантай, шийдвэр гаргах эрх бүхий этгээд болох Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн ажиллагсдын тооноос 20 хувиар илүү буюу 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, нийгмийн даатгалын зардалд нийт 193.1 сая төгрөг зарцуулж, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан олгохгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 166 мэдээллийг байршуулсан байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 211.8 сая төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6-р зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй, өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлого, зарлагын данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, баталгаажуулсан. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 108.6 сая төгрөгийн төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 28.7 сая төгрөгийн 2 алдааг залруулсан, 79.9 сая төгрөгийн 2 зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 64,246.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс аудитын шийдвэрийн хэрэгжилт 20.0 хувьтай байна. Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог багасгаж санхүүгийн ачааллыг бууруулах гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	64,246,052.3	1	12,849,210.4	20.0
Нийт дүн	3	64,246,052.3	1	12,849,210.4	20.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй, төслийн ажил эхлэхэд хэрэглэхээр нөөцөлсөн 778.8 сая төгрөгийн багаж техник, компьютер болон бусад хөрөнгийн хадгалалт хамгаалалтын асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрх хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийх асуудлыг удирдах дээд байгууллага анхааралдаа авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,588.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг залруулж бүртгэсэн.

Залруулсан алдаа:

- Хөгжлийн банканд төлөх 19,510.9 мянган ам. долларын зээл, зээлийн хүүгийн өрийн үлдэгдэлд тайлант оны эцэст ханшийн тэгшитгэл хийж, бүртгээгүйгээс ханшийн зөрүүний алдагдлыг санхүүгийн тайланд тусгаагүй;
- ХААН банк дахь хадгаламжийн дансны 115.9 мянган ам. долларын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийж, ханшийн зөрүүний олзыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Аудитаар нийт 129.9 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 12.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 110.3 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 7.6 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 129.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 79.0 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Байгууллагын албан хэрэгцээнд болон хөдөө орон нутагт явсан тээврийн хэрэгслүүдийн шатахуун зарцуулалтын тооцоог Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан норм, нормативын дагуу бодож, шатахууны үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс 5.5 сая төгрөгийн шатахуун нормоос илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Зам, тээврийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад "жишиг нормыг шууд үндсэн норм болгон мөрдөж болох бөгөөд тодорхой хугацаанд шатахуун зарцуулалтын сорил, туршилтыг явуулсны үндсэн дээр бодит зарцуулалтад тулгуурлан үндсэн нормыг тогтоож мөрдөнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Байгууллагын албан хэрэгцээнд болон хөдөө орон нутагт явсан тээврийн хэрэгслүүдэд илүү олгосон шатахууны төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин байгууллагын харилцах данснаас 35 удаагийн гүйлгээгээр 6.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 6.6 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө авах, гэрээний төсөл, захирлын тушаалын төслийг хянуулж зөвлөгөө авах зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр захиргааны ахлах ажилтаны хийх ажлын чиг үүрэгтэй давхардуулан өмгөөллийн "Кватуор адвокатус" ХХК, иргэн Б.Энхтүвшинтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, сар бүр 3.0 сая төгрөг олгож 36.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан олгохгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө авахад төлбөр өгч, илүү зардал гаргасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тус байгууллага нь Баянзүрх дүүргийн 26-р хороо, Сакура оффис таврын 9 давхарт 223.28 м2 оффисын талбайг түрээслэх, ашиглах гэрээг нэр бүхий нэг иргэнтэй байгуулахдаа 1м.кв талбайн түрээсийн 1 сарын төлбөрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1.м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаараас 27.3 сая төгрөгөөр хэтэрсэн дүнгээр тохиролцож, нийт 73.2 сая төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 төгрөгөөр тогтоосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨБЗГ-ын "төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" 139 дүгээр тогтоолыг зөрчсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэлгүй 7.6 сая төгрөгийн шатахуун болон албан томилолтын зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолт болон шатахууны тооцоо хийхдээ анхан шатны баримтыг хууль, журамд заасны дагуу бүрдүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөгжлийн банканд төлөх 19,510.9 мянган ам долларын зээл, зээлийн хүүгийн өрийг тайлант оны эцэст ханшийн тэгшитгэл хийж, бүртгээгүйгээс ханшийн зөрүүний алдагдлыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	2,572,924.4			1	2,572,924.4	1	2,572,924.4				
ХААН банкин дахь 5038159608 тоот хадгаламжийн дансны 115.9 мянган ам долларын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийж, санхүүгийн тайланд тусгаагүй байна	1	15,148.8			1	15,148.8	1	15,148.8				
Дүн	2	2,588,073.2	-	-	2	2,588,073.2	2	2,588,073.2				

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын албан хэрэгцээнд болон хөдөө орон нутагт явдаг 2 тээврийн хэрэгсэлд ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг мөрдөхгүйгээр 5,457.2 мянган төгрөгийн шатахууныг илүү олгосон байна.	1	5,457.3	1	5,457.3								
Тус компанийн харилцах данснаас 6,579.18 мянган төгрөгийг хувийн хэрэглээнд зарцуулсан байна.	1	6,579.2	1	6,579.2								
Анхан шатны баримтын бүрдэлгүй 7.6 сая төгрөгийн шатахуун, албан томилолтын зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	7,611.6					1	7,611.6				
Тус байгууллага нь БЗД-ийн 26-р хороо, Сакура оффисын 9 давхарт 223.28 м2 оффисын талбайг түрээслэх, ашиглах гэрээг нэр бүхий нэг иргэнтэй байгуулахдаа 1 сарын нэг м.кв-ийн талбайн түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан дүнгээс 27,328.00 төгрөгөөр илүү дүнгээр тохиролцож, нийт 73.2 сая төгрөгийн илүү зардал гаргасан байна.	1	73,221.6			1	73,221.6						
Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хууль зүйн зөвлөгөө авах, гэрээний болон захирлын тушаалын төслийг хянуулах зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр өмгөөллийн "Кватуор адвокатус" ХХК, иргэн	1	37,125.0			1	37,125.0						

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Б.Энхтүвшинтэй гэрээ байгуулж, сар бүр 3.0 сая төгрөг олгосон байна												
Дүн	5	129,994.7	2	12,036.5	2	110,346.6	1	7,611.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 166 мэдээллийг байршуулсан байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 211,826.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй байна.	1	211,826.0			1	211,826.0		
Дүн	1	211,826.0			1	211,826.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эрчим хүчний сайдын 2025 оны А/31 дүгээр тушаалаар нийт ажиллагсдыг 16 байхаар баталсан бөгөөд тайлант оны эцсээр 10 орон тоотой, шийдвэр гаргах эрх бүхий этгээд болох ТУЗ нь компанийн ажиллагсдын тооноос 20 хувиар илүү буюу 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, ТУЗ-ийн цалин, НДШ-ийн зардалд нийт 193.1 сая төгрөг зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	193,080.0			1	193,080.0		
Дүн	1	193,080.0			1	193,080.0		
Нийт дүн	2	404,906.0			2	404,906.0		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 137/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/60/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын албан хэрэгцээнд болон хөдөө орон нутагт албан томилолтоор ажилласан тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын тооцоог Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан норм, нормативын дагуу бодож, шатахууны үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс 5,457,274.00 /Таван сая дөрвөн зуун тавин долоон мянга хоёр зуун далан дөрвөн/ төгрөгийн шатахуун илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "жишиг нормыг шууд үндсэн норм болгон мөрдөж болох бөгөөд тодорхой хугацаанд шатахуун зарцуулалтын сорил, туршилтыг явуулсны үндсэн дээр бодит зарцуулалтад тулгуурлан үндсэн нормыг тогтоож мөрдөнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- 1 Байгууллагын албан хэрэгцээнд болон хөдөө орон нутагт албан томилолтоор ажилласан тээврийн хэрэгслүүдэд илүү олгосон шатахууны үнэ 5,457,274.00 /Таван сая дөрвөн зуун тавин долоон мянга хоёр зуун далан дөрвөн/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч /Г.Найдан/-р нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- 2 Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Тавантолгой дулааны цахилгаан станцын гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/, ерөнхий нягтлан бодогч /Г.Найдан/ нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 138/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин байгууллагын харилцах дансаас 35 удаагийн гүйлгээгээр 6,579,176.00 (Зургаан сая таван зуун далан есөн мянга нэг зуун далан зургаан) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-т "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 6,579,176.00 (Зургаан сая таван зуун далан есөн мянга нэг зуун далан зургаан) төгрөгийг гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/-р нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Тавантолгой дулааны цахилгаан станцын ерөнхий нягтлан бодогч /Г.Найдан/-д хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-3 Docx

1526200096



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 586/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА - СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний сайдын 2025 оны А/31 дүгээр тушаалаар үндсэн ажилчдын орон тоог 16 байхаар баталсан бөгөөд тайлант оны эцсийн байдлаар 10 үндсэн ажилтантай, шийдвэр гаргах эрх бүхий этгээд болох Төлөөлөн удирдах зөвлөл нь 12 гишүүнтэй буюу компанийн ажиллагсдын тооноос 20 хувиар илүү хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Тайлант онд гишүүдийн цалин, нийгмийн даатгалын зардалд нийт 193,080,000.00 /Нэг зуун ерэн гурван сая наян мянган/ төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан олгохгүй байх", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дээр дурдсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой дулааны цахилгаан станцын гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/, ерөнхий нягтлан бодогч /Г.Найдан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 587/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Баянзүрх дүүргийн 26-р хороо, Сакура оффисын 9 давхарт 223.28 м2 оффисын талбайг түрээслэх, ашиглалт үйлчилгээний гэрээг нэр бүхий нэг иргэнтэй байгуулахдаа 1 сарын нэг м.кв-ийн талбайн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан дүнгээс 27,328.00 /Хорин долоон мянга гурван зуун хорин найман мянган/ төгрөгөөр илүү дүнгээр тохиролцож, нийт 73,221,600.00 /Далан гурван сая хоёр зуун хорин нэгэн мянган зургаан зуун/ төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" 2024 оны 139 дүгээр тогтоолын 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан тарифаас өндөр дүнгээр түрээсийн төлбөрийг тогтоосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой дулааны цахилгаан станцын гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/, ерөнхий нягтлан бодогч /Т.Найдан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 588/АД150092

Улаанбаатар хот

САГ - 2026/60/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө авах, гэрээний болон захирлын тушаалын төслийг хянуулах зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр захиргааны ахлах мэргэжилтний хийх ажлын чиг үүрэгтэй давхардуулан өмгөөллийн "Кватуор адвокатус" ХХК, иргэн Б.Энхтүвшинтэй гэрээ байгуулж, нийт 37,125,000.00 /Гучин долоон сая нэг зуун хорин таван/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан олгохгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон тушаалын төсөл хянах, хууль зүйн зөвлөгөө авахаар гэрээ байгуулж, төлбөр олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой дулааны цахилгаан станцын гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/, ерөнхий нягтлан бодогч /Т.Найдан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 589/A0150092

Улаанбаатар хот

САГ-2026/60/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 211,826,027.00 /Хоёр зуун арван нэгэн сая найман зуун хорин зургаан мянга хорин долоон/ төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй, өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тавантолгой дулааны цахилгаан станцын гүйцэтгэх захирал /Г.Тэнгэр/, ерөнхий нягтлан бодогч /Т.Найдан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН

